
	(ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллеж)	Захирлын 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн тоот тушаалын наймдугаар хавсралт	
Баталсан: ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал  (Ч.Эрдэнэтуяа)		Баталсан огноо: 2026.01.20	Хуудасны тоо: 6
Баримт бичгийг хариуцагч: Захирлын туслах, архив бичиг хэрэг хариуцсан ажилтан <small>ШТА1659 1124080015 9048014</small>		Танилцах албан тушаалтнууд: Анги удирдсан багш нар болон нийт суралцагчид	

СУРАЛЦАГЧИЙН ДҮРЭМ

Эх хувь

Баримтжуулсан мэдээллийн дугаар:
Хувилбарын дугаар: **V1.2026**

Түгээлт




Энэ дүрэм нь манай байгууллагын өмч юм. Уг баримт бичгийг бичгээр зөвшөөрөл аваагүй үед бүхэлд нь эсвэл хэсэгчлэн байгууллагаас гадагш түгээхгүй.

Энэ дүрмийн батлагдсан албан ёсны хяналттай хуулбар нь цаасан хэлбэрээр бичиг хэргийн ажилтны баримт бичгийн хавтсанд мөн байгууллагын сервер компьютерт PDF файлаар хадгалагдана. Уг PDF файл зөвшөөрөгдсөн бүх ажилтнууд болон сонирхогч талуудад нээлттэй байна.

Дээр дурдсанаас бусад бүх цаасан болон цахим хуулбарыг зөвхөн лавлагаа болгон ашиглах хяналтгүй хуулбар гэж үзнэ.

ЗӨВШӨӨРӨЛ

Гарын үсэг нь удирдлагын тогтолцооны энэхүү дүрмийг хянаж, зөвшөөрснийг гэрчлэх бөгөөд гарын үсэг зурсан талууд энд агуулагдаж буй бүх шаардлагуудыг мэдэж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээсэн болохыг харуулна.

	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
Боловсруулсан	Нийгмийн ажилтан	Батжаргал Мөнхдэдгэр	2026.01.16	
Хянасан	Сургалтын менежер	Лувсандорж Чингэрэл	2026.01.20	
Зөвшөөрсөн	ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал	Чимэд Эрдэнэтуяа	2026.01.20	


НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Журмын өөрчлөлт нь процесс болон бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байгаа эсэхийг хянаж баталгаажуулна. Өөрчлөлтийн агуулга хэсэгт журамд орсон өөрчлөлтийг тэмдэглэнэ.

Өөрчлөлт оруулсан бүлэг	Өөрчлөлтийн товч утга	Хувилбарын дугаар	Сүүлд шинэчлэгдсэн огноо	Боловсруулж, шинэчилсэн албан тушаалтан, овог, нэр	Баталсан албан тушаалтан, овог, нэр

АГУУЛГА

НЭГ. Ерөнхий зүйл.....	1
ХОЁР. Зорилго.....	1
ГУРАВ. Суралцагчийн сургууль, олон нийтийн газар баримтлах дүрэм.....	1-2
ДӨРӨВ. Суралцагчийн эрх, үүрэг	3-4
ТАВ. Суралцагчийн ёс зүй.....	4-5
ЗУРГАА. Суралцагчийн ёс зүй.....	5-6
ДОЛОО. Авах арга хэмжээ	6

	№ Д-5-001 Суралцагчийн дүрэм Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Суралцагчийн суралцах үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёс зүйн зарчим, хэм хэмжээг сахин тогтоож, хэвшүүлэн сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, холбогдох гомдол саналыг хүлээн авах шийдвэрлэх, хичээл сургалтын үед зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Энэхүү дүрэмд Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн нийт суралцагчид хамаарна.

1.3.Суралцагч нь тухайн сурч буй мэргэжлийнхээ дагуу сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний агуулгыг хугацаанд нь бүрэн эзэмшиж, ёс зүйн хэм хэмжээг баримтлан суралцана.

1.4.Суралцагч бүр нь энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.

Хоёр.Зорилго

2.1.Суралцагчдын ёс зүйн зарчим, хэм хэмжээг сахин тогтоож, хэвшүүлэх, бие даан сурч боловсрох, хөгжих, авьяас чадвараа нээн хөгжүүлэхтэй холбогдсон харилцаа, тэдний эрх үүргийг зохицуулахад энэхүү дүрмийн зорилго оршино.


Гурав.Суралцагчийн сургууль, олон нийтийн газар баримтлах дүрэм

3.1.Тухайн хичээл дадлагын бэлтгэлийг бүрэн хангаж, хичээл эхлэхээс 15 минутын өмнө ирсэн байх.

3.2.Хичээлийн хонх дуугармагц анги танхимдаа орж хичээлдээ идэвхтэй оролцож, хичээлийн цагийн хуваарийг мөрдөх.

3.3.Завсарлагаанаар хичээлээс хоцрохгүй, хичээлийн явцад ангиас гарах тохиолдолд тухайн хичээл зааж буй багшаас заавал зөвшөөрөл авах.

3.4.Сургууль, анги танхимд, хичээлийн цагаар малгай, гадуур хувцас өмсөхгүй байх. Хичээл сургалтад дүрэмт хувцас, дадлагын хувцас бүрэн өмсөх.

	№ Д-5-001 Суралцагчийн дүрэм Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

3.5.Багшийн зүгээс тавьсан шаардлага, өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, багш шавийн хоорондын харилцааг хүндэтгэн дээдлэх.

3.6.Сургуулийн орчинд архи, согтууруулах ундаа, мансууруулах төрлийн бодис хэрэглэх, тамхи татахыг хориглоно.

3.7.Бусдын биед зөвшөөрөлгүй хүрэх болон, санаатайгаар халдах, гэмтээхийг хатуу хориглоно.

3.8.Бусдын эд зүйлд зөвшөөрөлгүй хүрэх, авч хэрэглэхгүй байх.

3.9.Бүдүүлэг үг хэлэх, чанга дуу авиа гаргах, бусдыг заналхийлэх, хуурч мэхлэх зэрэг сөрөг үзэгдлүүд үйлдэхийг хориглоно.

3.10.Бусдыг яс үндэс, харьяалал, арьс өнгө, хүйс, нас, шашин шүтлэг, бие махбодын байдал, зүс царай гэх мэтээр ялгаварлан ханахыг хатуу хориглоно.

3.11.Өөрийн авьяас сонирхол, хэрэгцээнд тулгуурлан хичээлээс гадуурх мэргэжлийн болон бусад сургалт, секц дугуйлан, сургуулийн захиргаа, байгууллагаас зохиож буй үйл ажиллагаа, тэмцээн уралдаанд идэвхтэй оролцож авьяас чадвараа хөгжүүлэх.

3.12.Сургуулийн болон бусад орчинд найз нөхөд, үе тэнгийхэн, дүү нартаа зөв үлгэр дуурайл үзүүлэх.

3.13.Хүрээлэн буй орчин, ногоон байгаль, нийтийн эзэмшлийн талбай, эд хөрөнгийг хайрлан хамгаалах.


3.14.Суралцагч нь бие даан суралцах, хөгжих арга барилаа тасралтгүй сайжруулах.

3.15.Сургууль, багшийн зүгээс эцэг эх, асран хамгаалагчид хандсан мөн эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс сургуульд хандсан асуудал, мэдээ мэдээллийг үнэн зөв танилцуулах

3.16.Сургууль болон номын сан, дотуур байрны дүрэм журмыг биелүүлэх, дагаж мөрдөх.

3.17.Замын хөдөлгөөн, гудамж талбайн дүрмийг баримтлан хөдөлгөөнд оролцож аюулгүй байдлыг эрхэмлэх.

3.18.Сургууль, олон нийтийн газарт бусадтай зөв боловсон харьцаж иргэний үүргээ биелүүлж, хувийн ёс зүйтэй байх.

 ВМНОГОВЬ ПОЛИТЕХНИЧЕСКИЙ КОЛЛЕЖ	№ Д-5-001 Суралцагчийн дүрэм Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---


Дөрөв.Суралцагчийн эрх, үүрэг

4.1 Суралцагч нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- 4.1.1.сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний дагуу чанартай боловсрол эзэмших;
- 4.1.2.эрүүл, аюулгүй сургалтын орчинд суралцах;
- 4.1.3.хичээл, сургалтын үйл ажиллагаанд санал хүсэлтээ чөлөөтэй илэрхийлэх;
- 4.1.4.сургалтын үнэлгээ, дүнгийн талаарх мэдээллийг ил тод, шударгаар авах;
- 4.1.5.сургуулийн дугуйлан, клуб, тэмцээн уралдаан, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох;
- 4.1.6.суралцагчдын өөрөө удирдах байгууллагад гишүүнээр элсэх;
- 4.1.7.сэтгэлзүй, эрүүл мэндийн зөвлөгөө үйлчилгээ авах;
- 4.1.8.ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийллээс хамгаалагдах;
- 4.1.9.хууль тогтоомж, сургуулийн дүрэм журамд нийцүүлэн эрхээ хамгаалуулах;
- 4.1.10.сургуулийн дотоод дүрэм журамд нийцүүлэн асуудлаа шийдвэрлүүлэх;

4.2 Суралцагчийн хүлээх үүрэг. Үүнд:

- 4.2.1.сургуулийн дүрэм, журам, дотоод хэм хэмжээг мөрдөх;
- 4.2.2.хичээлд тогтмол, идэвхтэй хамрагдаж, бие даалт, даалгаврыг хугацаанд нь биелүүлэх;
- 4.2.3.багш, ажилтан, суралцагчдын эрх, нэр төрийг хүндэтгэн харилцах;
- 4.2.4.хувь хүний ёс зүй, харилцааны соёлыг баримтлах;
- 4.2.5.сургуулийн нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, ногоон орчныг хайрлан хамгаалах;
- 4.2.6.аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм, зааврыг мөрдөх;
- 4.2.7.архидан согтуурах, тамхи татах, мансууруулах бодис хэрэглэхгүй байх;
- 4.2.8.цахим орчинд зүй зохистой, хариуцлагатай харилцах;

	№ Д-5-001 Суралцагчийн дүрэм Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

4.2.9.гэмт хэрэг, зөрчил, сахилгын зөрчил гаргахгүй байх;

4.2.10.өөрийн сурлага, хүмүүжил, хөгжлийн төлөө хариуцлага хүлээх;

Тав.Суралцагчийн ёс зүй

5.1.Суралцагч нь дараах үндсэн зарчмыг баримтална. Үүнд:

5.1.1.хүнлэг энэрэнгүй, шударга, хариуцлагатай байх;

5.1.2.бусдыг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх;

5.1.3 хууль, дүрэм, журмыг сахин биелүүлэх

5.1.4 ёс суртахуунтай, зөв үлгэр дуурайлал үзүүлэх

5.2.Суралцагчийн ёс зүйн хэм хэмжээ

Багш, ажилтан, суралцагчидтай харилцах ёс зүй

5.2.1 багш, ажилтан бусад суралцагчтай эелдэг, хүндэтгэлтэй харилцах;

5.2.2 доромжилсон, заналхийлсэн, бүдүүлэг үг хэллэг, үйлдэл гаргахгүй байх;

5.2.3 маргаан зөрчлийг тайван, зөв аргаар шийдвэрлэх;

5.2.4 багш шавийн харилцааг эрхэмлэх;

5.2.5 ёс зүйн зөрчил гаргасан суралцагчийг нуун дарагдуулах;

5.2.6 охид хөвгүүд, хүн бүрийг адил тэгш хүндэтгэж, хэвшмэл үг хэллэг хэлэхгүй жөндөрийн мэдрэмжтэй байх;

5.2.7 сургууль болон багш ажилтны нэр хүндэд санаатай болон санаандгүй халдах;

Суралцах үйл ажиллагаанд баримтлах ёс зүй


5.2.8 хичээлд идэвхтэй, хариуцлагатай оролцох;

5.2.9 хичээл таслахгүй, хоцрохгүй байх;

5.2.10 багшийн өгсөн үүрэг, даалгаврыг цаг тухай бүрд биелүүлэх;

5.2.11 сургалтын орчны эд хөрөнгийг хайрлан хамгаалах;

5.2.12 сургуулийн болон номын сан, дотуур байрын дүрэм журмыг биелүүлэх, дагаж мөрдөх;

	№ Д-5-001 Суралцагчийн дүрэм Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

Хувийн сахилга бат, хандлага төлөвшил

- 5.2.13 сургуулийн дүрэмт хувцсыг бүрэн өмсөх;
- 5.2.14 оюутны үнэмлэхийг тогтмол зүүж хэвших;
- 5.2.15 гоо зүй, үс засалтад анхаарах;
- 5.2.16 тод өнгөөр үсээ будахгүй байх;
- 5.2.17 сургуулийн дотоод дүрэм журмыг мөрдөх;
- 5.2.18 архи согтууруулах ундаа, утаат болон электрон тамхи, мансууруулах бодис хэрэглэхгүй байх;
- 5.2.19 цахим орчинд ёс зүйтэй харилцах, бусдын нэр төрд халдахгүй байх;
- 5.2.20 бусдын биед санаатай халдахгүй байх;
- 5.2.21.бусдын эд зүйлд зөвшөөрөлгүй хүрэхгүй байх;

Зургаа.Дараах үйлдлийг ёс зүйн зохисгүй хэлбэр гэнэ

- 6.1 Сургуулийн удирдлага, багш ажилтны шаардлагыг үл хүндэтгэх.
- 6.2 Сургуулийн болон дотуур байр олон нийтийн газар бусадтай зүй бус харьцах.
- 6.3 Мансууруулах төрлийн бодис, утаат болон электрон тамхи хэрэглэх, архидан согтуурах.
- 6.4 Бусдын амар амгалан тайван байдлыг алдагдуулах, гэм хор учруулах.
- 6.5 Бусдыг үл хүндэтгэх татаас татах (мөнгөн болон бусад хэлбэрээр) бусдын биед халдах сургуулийн өмчид халдах, эвдлэх гэмтээх.
- 6.6 Сургуулийн орчинд шаардлагагүй зүйл биедээ авч явах.
- 6.7 Бусдыг ялгаварлан гадуурхах.
- 6.8 Сургуулийн орчин, нийтийн эзэмшлийн газарт чанга дуу авиа гаргах исгэрэх, ноцолдох бүдүүлэг үг хэллэг авиа гаргах, хог шүлс хаях, бөөгнөрөл үүсгэх.
- 6.9 Хичээл таслах хоцрох, хичээл дундуур зөвшөөрөлгүй гарах
- 6.10 Хичээлийн цагаар шаардлагагүй үед зөвшөөрөлгүй гар утас, таблет зэрэг ухаалаг төхөөрөмж ашиглах.

	№ Д-5-001 Суралцагчийн дүрэм Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

6.11 Сургуулийн хашаа давах, ойр орчмын айл, албан байгууллагад хүндрэл учруулах.

6.12 Цахим орчин, олон нийтэд бусдын хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй ашиглах, зүй бус үг хэлээр дайрч доромжлох, гүтгэх, хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халдах.

6.13 Жижүүр багш, суралцагчдын тавьсан шаардлагыг биелүүлэхгүй байх.

Долоо.Авах арга хэмжээ

7.1 **Хөнгөн зөрчил** (хичээлийн цагаас хоцрох, дүрэмт хувцасгүй ирэх, хичээл шалтгаангүй тасалсан гэх мэт)

- 7.1.1 аман сануулга өгөх;
- 7.1.2 зөвлөн тайлбарлах, ойлгуулах;
- 7.1.3 анги удирдсан багш анхааруулга өгөх;
- 7.1.4 зөрчил гаргасан талаар бүртгэж авах;

7.2 **Давтан болон дунд зэргийн зөрчил** (цахим орчинд болон бусад үед ёс зүйгүй үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, хичээлийн дэг журам алдагдуулах, хичээл орж буй багшид болон бусдад саад учруулах гэх мэт)

- 7.2.1 албан ёсны сануулга (бичгээр);
- 7.2.2 эцэг эх, асран хамгаалагчид мэдэгдэх;
- 7.2.3 сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй уулзуулах;
- 7.2.4 суралцагч амлалтын хуудас бичиж өгөх;

7.3 **Хүнд зөрчил** (зодоон хийх, үе тэнгийн дээрэлхэлд, эд зүйл эвдэх, согтууруулах ундаа, тамхи хэрэглэх, гэмт хэрэг зөрчилд холбогдох гэх мэт)

- 7.3.1 сургуулийн удирдлагад мэдэгдэж хэлэлцэх;
- 7.3.2 сургуулийн дотоод журмын дагуу арга хэмжээ авах;
- 7.3.3 холбогдох мэргэжлийн байгууллагад мэдээлэх (шаардлагатай тохиолдолд);
- 7.3.4 нөхөн сэргээх, хүмүүжлийн арга хэмжээ;
- 7.3.5 суралцагч уучлал хүсэх, тайлбар бичих;
- 7.3.6 сайн дурын ажил, нийгмийн ажилд оролцуулах;
- 7.3.7 хүмүүжлийн сургалт, зөвлөгөөнд хамруулах;
- 7.3.8 цаашид үргэлжлүүлэн суралцах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэх;